

## Зээлийн хүүг тооцон мэдээлэх талаархи зарим саналууд

Мөнгөний бодлого судалгааны  
газрын захирал Б.Энххуяг

### Оршил

Эдийн засаг дахь гол үнийн дохионуудын нэг нь зээлийн хүү мөн. Тэгвэл энэ хүү манай эдийн засагт өндөр байгаа болон түүнийг хэрхэн бууруулах талаархи сэдэв манай нийгмийн анхаарал татсан асуудлуудын нэг яах аргагүй мөн. Энэ судалгааны ажлын зорилго нь Монголбанкаас олон нийтэд мэдээлж буй зээлийн хүүг тооцон мэдээлэх аргачлалд шүүмжлэлтэй хандахад оршино.

### Зээлийн хүүг тооцон мэдээлэх талаар

Монголбанк өөрийн сар бүрийн мөнгөний тоймдоо банкуудын төгрөг болон валютын зээлийн жигнэсэн дундаж хүүг зарладаг. Дээрх хүү нь 2005 оны 9 дүгээр сарын байдлаар төгрөгөөр жилийн 30.5 хувь, валютаар жилийн 16.2 хувь байна. Энэ нь өнгөрсөн 8 дугаар сард манай арилжааны банкуудаас харицагчдаа олгосон зээлийн хүүг олгосон зээл тус бүрийн дүнгээр жигнэж тооцсон хүү төгрөгөөр жилийн 30.5 хувь, валютаар жилийн 16.2 хувь байна гэсэн үг. Зээлийн харилцаанд банк зээлдэгч хоёр дөнгөж орох үеийн, банк зээлдэгчээс авахаар урьдчилан тохиролцсон зээлийн хүүг Монголбанк сарын мөнгөний тоймдоо зарлан мэдээлдэг.

Нөгөө талаас Монголбанк арилжааны банк бүрээс өнгөрсөн жилийн орлого зарлагын мэдээг хүлээн авдагт тухайн жилдээ банк зээлдэгчээс бодитой төлүүлж авсан зээлийн хүүний орлогын мэдээ багтдаг. Энэ мэдээн дэхь хүүний орлогыг тухайн жилийн зээлийн эхний болон эцсийн үлдэгдлийн арифметик дунджад хуваахад банк тухайн жилийн зээлээсээ бодитойгоор олж авсан хүүний түвшин тооцогдоно.

2003, 2004 онуудын арилжааны банкуудын жилийн орлого зарлагын мэдээний хүүний орлогыг зээлийн тухайн оны эхний болон эцсийн үлдэгдлийн арифметик дунджад хуваан зээлийн бодит хүүг банкны салбарын хэмжээгээр Хавсралт 1-д тооцон зээлийн зарласан хүүтэй харьцуулав.

Хавсралт 1-ээс үзэхэд манай банкуудын харилцагчаас авахаар анх тохирсон болон хэрэг дээрээ зээлдэгчээр төлүүлсэн хоёрын хооронд 7 орчим нэгжийн зөрүү байсан нь 2003, 2004 онуудын хувьд ажиглагдана. Ямар ч байсан анхны тохиролцсоноос доогуур зээлийн хүүг банкууд авдаг нь эдийн засаг дахь зээлийн хүүний өндөр дарамтын талаар ярилцахын өмнө бодит байдалд ойрхон тоог хаана хаана хэрэглэж хэвших ёстойг дээрх хавсралт анхааруулж

байна. Иймд Монголбанк банкуудын зарласан зээлийн хүүг сар тутам мэдээлхээс гадна банкуудын бодитой олж авч байгаа зээлийн хүүний тувшиング мөн мэдээлж хэвших нь зүйтэй санагдлаа.

2005 оны 9 дүгээр сарын байдлаар банкны салбарт нийт зээлийн үлдэгдлээрээ эхний 9 байрт орсон арилжааны банк бүрээр зээлийн зарласан болон бодит хүүний зөрүүг 2003, 2004 оны жилийн эцсээр тооцон хавсралт 2-10-т үзүүлэв. 2003, 2004 оны явцад Монголбанкинд банкуудаас ирүүлдэг орлого, зарлагын тайлангийн хэв маягт өөрчлөгдөж байсан тул зээлийн хүүний мэдээг түүвэрлэх аргаар банк нэг бүрээр гаргасан. Тухайлбал 2003 оны банкуудын орлого, зарлагын жилийн тайлангаас хүүгийн орлого гэсэн зүйл ангиас зөвхөн “зээлийн хүүний орлого, хугацаа хэтэрсэн зээлийн хүүний орлого” гэсэн хоёр зүйл ангийн нийлбэрийг судалгаанд ашиглан ЗГ-ын үнэт цаас, Монголбанк болон бусад банкнаас авсан хүүгийн орлого, банк хоорондын зах болон гадаадын банкнаас авсан хүүний орлого зэргийг орхисон болно. 2004 оны банкуудын орлого, зарлагын жилийн тайлангаас зээлийн хүүгийн орлого гэсэн бүлгээс Монголбанк, бусад банк санхүүгийн байгууллагаас авсан хүүг хасч тооцсон.

Мөн зээлийн багцад нь валютаар олгогдсон зээл өндөр хувьтай Голомт, Худалдаа хөгжил болон Чингис Хaan банкуудын хувьд валютаар зарласан хүүг бодит хүүтэй давхар харьцуулав.

Зарласан хүүний түвшнээр төгрөгийн зээлийн хувьд Голомт, Худалдаа хөгжил, валютын зээлээр Чингис Хaan банк хамгийн бага түвшинд хүүгээ зарладаг нь харагдаж байна. Чингис Хaan банк зөвхөн валютын зээл олгон түүний хүүгээ 2003 онд жилийн 12.4 хувь, 2004 онд 11.4 хувиар зарласан байв. Нөгөөтэйгүүр бичил зээлээр мэргэждэг ХАС, ХААН банкуудын зарласан хүү бусад банкуудынхаас өндөр, сарын 3-3.5 хувь байгаа нь энэ банкуудын бичил зээлийн өндөр өртгөөр тайлбарладаг. Төгрөгийн зээлийн зарласан хүүний огцом бууралт Улаанбаатар хотын болон Зоос банкууд дээрх 2 жилийн хугацаанд ажиглагдсан. Зээлийн зарласан хүү нь өссөн цорын ганц банк нь ХААН банк байна: зарласан хүү нь 2003 онд жилийн 36.5 хувь байснаа 2004 онд жилийн 39.2 болон өссөн.

Валютын зээлийн зарласан хүүг авч үзэхээр банкуудын хоорондын хүүний ялгаа эрс буурна. Валютын зээлийн хэмжээгээр системдээ тэргүүлдэг Голомт, Худалдаа Хөгжлийн Банкууд зарласан хүүгээ аажмаар буулгасан байхад Чингис Хaan банк тогтмол түвшинд барьж иржээ.

Банк бүрээр үзэхэд зарладаг болон төлүүлдэг зээлийн хүүний зөрүү дээр ихээхэн ялгаа байгаа нь харагдана. Анод, Худалдаа хөгжил, ХААН, Монгол шуудан банкуудын хувьд дээрх зөрүү хамгийн өндөр түвшинд байна. Ялангуяа ХААН банкны хувьд зарладаг, төлүүлдэгийн зөрүү хоёр жил дараалан 3.1 болон 8.5 нэгж гарчээ. Хамгийн өндөр бодит хүүтэй банкаар ХАС банк шалгарч ХААН, Зоос банкууд удаалав. Чингис Хaan банк зарласнаасаа илүү өндөр хэмжээний хүүг 2004 онд харилцагчдаасаа авснаа 2003 онд орж ирэх ёстой багагүй хэмжээний зээлийн хүү 2004 онд төлөгдсөнөөр тайлбарлав.

Хамгийн зээлийн хүүгээ зарласан түвшинд хүртэл төлүүлж чаддаг банкаар Зоос шалгарахаар байна.

Зарласан болон бодит хүүний зөрүү их байгааг хэд хэдэн учир шалтгаанаар тайлбарлаж болно: тухайн банкны зээлийн нөхцөл анхнаасаа зээлдэгчийн санхүүжсэн төслөөс хол зөрүүтэй байснаас зээлийн хэрэгжилтийн явцад банк зээлийнхээ хугацаа хүүг өөрчлөхөд хүрдэг. Татвараас зугтах үзэгдэл нь банкуудын хувьд зээлдэгчдийн зээл авах гэж танилцуулдаг тэнцлийг ахин нухаж бодит байдалд ойртуулах гэж цаг хугацаа алддаг сөрөг үр дагавартай байдаг. Тухайн зээлийн мөнгө эргэлтийн урсгалыг банкны эдийн засагч алдаатай тооцолох эрсдэл ч бас бий.

Монголбанкнаас арилжааны банкуудыг шалгах явцад зарим банкирууд зээлийн эргэн төлөгдөх хугацааг зориудаар зээлийн бодит байдлаас богиноор тогтоох практик илэрдэг нь зээлийг зохиомлоор хугацаа хэтрэлтэд оруулан зээлдэгчид зүй бус шахалт үзүүлэх зорилготой аж.

Зээлийн хүүг нэхэн төлүүлэх ажиллагаа нь дутагдалтай байх ялангуяа банкны дотоод ангиллаар чанаргүйд тооцсон зээлийг төлүүлэх явцад барьцаа хөрөнгийг банк өөрийн мэдэлд авах, энэ чиглэлээр шүүх, шүүхийн гүйцэтгэлийн албатай хамтран ажиллах, барьцаа хөрөнгийг борлуулах, хадгалах, өр барагдуулагчдыг урамшуулах, хугацаа хэтэрсэн зээлийн нөхцөл байдлыг дахин өөрчлөн шинэчлэх ур чадвараас хамаарна.

Зээл чанаргүй болох тохиолдолд банк барьцаа хөрөнгийг өөрийн болгон авахад шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийнхэн төдийлэн тус болохгүй байх, тэр битгий хэл дампуурсан зээлдэгчид хандтай шийдвэр зарим тохиолдолд гаргах нь зээлийн ерөнхий эрсдэлийг улам өндөржүүлэн хүүг өсгөнө.

Одоогийн мөрдөгдөж буй журмаар 90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн зээлийн хүүг тэнцлийн гадуур бүртгэж байгаа учраас зээлийн хүүний орлогод орсон зээлийн хүүний дийлэнхийг хугацаандаа байгаа чанартай зээлийн өрийн үлдэгдэл оруулдаг.

Зөрүү их байгаагийн тэс өөр тайлбарыг мөн хийж болох юм: зээлийн төсөл хэрэгжихийн хирээр өөрчлөгдөх гадаад дотоод орчны нөлөөллөөр банк, зээлдэгч хоёр зээлийн гэрээний нөхцөл байдлыг харилцан тохиролцсоны үндсэн дээр уян хатан өөрчилдөг байж болно. Харин ингэх нөхцөлд банкны хувьд орох, гарах мөнгөн хөрөнгийн урсгалыг урьдчилж төлөвлөн зохицуулахад ихээхэн хүндрэл учирна.

Банкны салбарын чанаргүй зээлийн хувь хэмжээг олон нийтэд Монголбанк мэдээлдэг арга барилаа мөн эргэн нягтлах ёстой, “чанаргүй зээл” гэдэг нь зээлийг олгосон банк зээлээр санхүүжсэн төсөл хэрэгжих явцдаа гадна, дотнын нөлөөгөөр хугацаандаа төлөгдөхгүй болох магадлалаар тооцсон банкны өөрийн дотоодын ангилал байдаг, харин харилцагч бол банкнаас зээл авсан л бол эргүүлж төлөх үүрэг хүлээдгийн хувьд бүх зээл хугацаандаа, чанартай гэж нийгэмд зарлагдах нь зүйд илүү нийцнэ.

Банкны салбарын хэмжээгээр бодитойгоор төлүүлсэн зээлийн хүүний хувь хэмжээ 2004 онд 2003 оны түвшнээс өссөнийг банкуудын зээлийн араас тавих нэхэл чангарсан, энэ онуудад эдийн засаг хурдацтай өсч макро орчин тогтвортой байсан, банкны зээлийн холбогдолтой хууль эрх зүйн актуудыг боловсронгуй болгох чиглэлээр Монголбанк Улсын Их Хуралтай хамтран ажилласан зэрэгтэй холбон үзэж болно.

Энэхүү судалгааны ажлыг цаашид банкуудын орлого, зарлагын тайлангийн зүйл анги бүрээр зээл, хадгаламжийн хүүний зөрүүг илүүтэй нягтлан судлах, мөн хадгаламжийн хүүг зарласан, төлсөн байдлаар нь салган үзэх зэргээр илүү боловсронгуй өргөн хүрээтэй болгон сайжруулж болно хэмээн үзэж байна.

## Дүгнэлт

Зээлийн өндөр хүүний дарамт хэрэг дээрээ тийм өндөр биш болох нь судалгааны ажлын дүнгээс харагдаж байна. Банкууд 2003 онд зээлдэгчээрээ жилийн 24.1 хувь буюу сарын 2 хувь, 2004 онд жилийн 19.4 хувь буюу сарын 1.9 хувийн хүүг төлүүлсэн тооцоо гарч байна. Иймд Монголбанк өөрийн сар тутмын мөнгөний тоймдоо жигнэсэн зарласан зээлийн хүүг мэдээлж байхаас гадна банкны салбарын зээлдэгчдийн үүрч буй ачааг үнэн бодитойгоор үзүүлэх бодит зээлийн хүүний түвшинг хамт мэдээлж байх нь илүү бүрэн гүйцэд мэдээлэл болохоор байна.

Хавсралтууд

Хавсралт 1. Банкны салбарын зээлийн зарласан хүү болон бодит хүүний харьцуулалт

Он	Банкны салбарын төгрөгийн зээлийн зарласан хүү, жилийн хувиар	Банкны салбарын зээлийн хүүний орлого, сая төгрөгөөр	Банкны салбарын зээлийн үлдэгдэл, сая төгрөгөөр	Банкны салбарын зээлийн бодит хүү, жилийн хувиар	Төгрөгийн зээлийн зарласан болон бодит хүүний зөрүү, нэгжээр
2003	31.5	82503.1	341913.4	24.1	7.4
2004	30.0	119980.1	520755.7	23.0	7.0

Тайлбар:

- 1/Банкны салбарын зарласан хүү гэдэгт тухайн оны 12 дугаар сард банкнаас зээлдэгчдэд олгосон зээлийг дүнгээр нь жигнэсэн зээлийн дундаж хүүг авав.
- 2/ Банкны салбарын тухайн жилийн зээлийн хүүний орлогод жилийн орлого зарлагын мэдээний зээлийн хүүний орлого, хугацаа хэтэрсэн зээлийн хүүний орлого гэсэн хоёр зүйл ангийн нийлбэрийг оруулж "банк хоорондын зах", "Монголбанк болон бусад банкнаас авсан хүүгийн орлого" зэргийг оруулсангүй.
- 3/ Банкны салбарын тухайн жилийн зээлийн үлдэгдэлд тухайн жилийн зээлийн эхний болон эцсийн үлдэгдлийн арифметик дундажыг авав.
- 4/Банкны салбарын зээлийн бодит хүүг тухайн жилд банк харилцагчаараа төлүүлсэн зээлийн хүүний орлогыг банкны тухайн жилийн эцсийн үлдэгдэлд хувааж тооцов.

Хавсралт 2. Анод банкны зээлийн зарласан хүү болон бодит хүүний харьцуулалт

Он	Анодын төгрөгийн зээлийн зарласан хүү, жилийн хувиар	Анодын зээлийн хүүний орлого, сая төгрөгөөр	Анодын зээлийн үлдэгдэл, сая төгрөгөөр	Анодын зээлийн бодит хүү, жилийн хувиар	Төгрөгийн зээлийн зарласан болон бодит хүүний зөрүү, нэгжээр
<b>2003</b>	<b>34.2</b>	11404.6	47551.3	<b>24.0</b>	<b>10.2</b>
<b>2004</b>	<b>30.0</b>	22721.7	87066.8	<b>26.1</b>	<b>3.9</b>

Хавсралт 3. Голомт банкны зээлийн зарласан хүү болон бодит хүүний харьцуулалт

Он	Голомтын төгрөгийн зээлийн зарласан хүү, жилийн хувиар	Голомтынвалютын зээлийн зарласан хүү, жилийн хувиар	Голомтын зээлийн хүүний орлого, сая төгрөгөөр	Голомтын зээлийн үлдэгдэл, сая төгрөгөөр	Голомтын зээлийн бодит хүү, жилийн хувиар	Төгрөгийн зээлийн зарласан болон бодит хүүний зөрүү, нэгжээр	Валютын зээлийн зарласан болон бодит хүүний зөрүү, нэгжээр
<b>2003</b>	<b>25.5</b>	<b>21.1</b>	8690.4	42559.5	<b>20.4</b>	<b>5.1</b>	<b>0.7</b>
<b>2004</b>	<b>24.0</b>	<b>17.6</b>	12677.0	73504.7	<b>17.2</b>	<b>6.8</b>	<b>0.4</b>

Хавсралт 4. Зоос банкны зээлийн зарласан хүү болон бодит хүүний харьцуулалт

Он	Зоосын төгрөгийн зээлийн зарласан хүү, жилийн хувиар	Зоосын зээлийн хүүний орлого, сая төгрөгөөр	Зоосын зээлийн үлдэгдэл, сая төгрөгөөр	Зоосын зээлийн бодит хүү, жилийн хувиар	Төгрөгийн зээлийн зарласан болон бодит хүүний зөрүү, нэгжээр
<b>2003</b>	<b>32.0</b>	6940.0	22110.8	<b>31.4</b>	<b>0.6</b>
<b>2004</b>	<b>24.0</b>	8168.1	32274.6	<b>25.3</b>	<b>-1.3</b>

Хавсралт 5. Монгол шуудан банкны зээлийн зарласан хүү болон бодит хүүний харьцуулалт

Он	МШБ төгрөгийн зээлийн зарласан хүү, жилийн хувиар	МШБ зээлийн хүүний орлого, сая төгрөгөөр	МШБ зээлийн үлдэгдэл, сая төгрөгөөр	МШБ зээлийн бодит хүү, жилийн хувиар	Төгрөгийн зээлийн зарласан болон бодит хүүний зөрүү, нэгжээр
<b>2003</b>	<b>32.7</b>	6250.7	24257.9	<b>25.8</b>	<b>6.9</b>
<b>2004</b>	<b>28.4</b>	8168.1	37690.6	<b>21.7</b>	<b>6.7</b>

Хавсралт 6. Улаанбаатар хотын банкны зээлийн зарласан хүү болон бодит хүүний харьцуулалт

Он	УБХБ төгрөгийн зээлийн зарласан хүү, жилийн хувиар	УБХБ зээлийн хүүний орлого, сая төгрөгөөр	УБХБ зээлийн үлдэгдэл, сая төгрөгөөр	УБХБ зээлийн бодит хүү, жилийн хувиар	Төгрөгийн зээлийн зарласан болон бодит хүүний зөрүү, нэгжээр
<b>2003</b>	<b>25.7</b>	1580.7	7506.9	<b>21.1</b>	<b>4.6</b>
<b>2004</b>	<b>15.7</b>	1779.7	10704.3	<b>16.6</b>	<b>-0.9</b>

Хавсралт 7. ХАС хотын банкны зээлийн зарласан хүү болон бодит хүүний харьцуулалт

Он	ХАС төгрөгийн зээлийн зарласан хүү, жилийн хувиар	ХАС зээлийн хүүний орлого, сая төгрөгөөр	ХАС зээлийн үлдэгдэл сая төг.	ХАС зээлийн бодит хүү, жилийн хувиар	Төгрөгийн зээлийн зарласан болон бодит хүүний зөрүү, нэгжээр
<b>2003</b>	<b>40.0</b>	3573.3	8410.7	<b>42.5</b>	<b>-2.5</b>
<b>2004</b>	<b>37.2</b>	5746.7	15943.5	<b>36.0</b>	<b>1.2</b>

Хавсралт 8. ХААН банкны зээлийн зарласан хүү болон бодит хүүний харьцуулалт

Он	ХААН төгрөгийн зээлийн зарласан хүү, жилийн хувиар	ХААН зээлийн хүүний орлого, сая төгрөгөөр	ХААН зээлийн үлдэгдэл, сая төгрөгөөр	ХААН зээлийн бодит хүү, жилийн хувиар	Төгрөгийн зээлийн зарласан болон бодит хүүний зөрүү, нэгжээр
<b>2003</b>	<b>36.5</b>	13159.9	39397.1	<b>33.4</b>	<b>3.1</b>
<b>2004</b>	<b>39.2</b>	20898.1	68162.6	<b>30.7</b>	<b>8.5</b>

Хавсралт 9. Худалдаа хгжлийн банкны зээлийн зарласан хүү болон бодит хүүний харьцуулалт

Он	ХХБ төгрөгийн зээлийн зарласан хүү, жилийн хувиар	ХХБ валютын зээлийн зарласан хүү, жилийн хувиар	ХХБ зээлийн хүүний орлого, сая төгрөгөөр	ХХБ зээлийн боди т үлдэгдэл, сая төгрөгөөр	ХХБ зээлийн боди т хүү, жилийн хувиар	Төгрөгийн зээлийн зарласан болон бодит хүүний зөрүү, нэгжээр	Валютын зээлийн зарласан болон бодит хүүний зөрүү, нэгжээр
<b>2003</b>	<b>26.3</b>	<b>18.8</b>	9483.5	59538.6	<b>15.9</b>	<b>10.4</b>	<b>2.9</b>
<b>2004</b>	<b>25.2</b>	<b>16.4</b>	13593.7	79445.9	<b>17.1</b>	<b>8.1</b>	<b>-0.7</b>

Хавсралт 10. Чингис Хaan банкны зээлийн зарласан хүү болон бодит хүүний харьцуулалт

Он	ЧХБ төгрөгийн зээлийн зарласан хүү, жилийн хувиар	ЧХБ валютын зээлийн зарласан хүү, жилийн хувиар	ЧХБ зээлийн хүүний орлого, сая төгрөгөөр	ЧХБ зээлийн боди т үлдэгдэл, сая төгрөгөөр	ЧХБ зээлийн боди т хүү, жилийн хувиар	Төгрөгийн зээлийн зарласан болон бодит хүүний зөрүү, нэгжээр	Валютын зээлийн зарласан болон бодит хүүний зөрүү, нэгжээр
<b>2003</b>		<b>12.4</b>	5558.0	48734.5	<b>11.4</b>		<b>1.0</b>
<b>2004</b>		<b>11.4</b>	7405.4	34869.4	<b>21.2</b>		<b>-9.8</b>

1/Чингис Хaan банкны зээлийн багц 2004 онд буурсан мэт харагдах боловч энэ нь гадаадын оршин суугчид олгосон зээлийг тусд нь ангилан дотоодын зээлд оруулахгүй болсонтой холбоотой.

2/Чингис Хaan ББСБ нь 2003 оны 10 дугаар сард Чингис Хaan банк болон өөрчлөгдсөн.